



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Даланжаргалан сумын Засаг дарга 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ДГА-2019/5/СТА-ТТЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Сайншанд

2019 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 70522734      Цахим хаяг: DORNOGOVI@AUDIT.GOV.MN

Аудитын менежер: Ц.Лүндэгмаа

Утас: 70523020      Цахим хаяг: lundegmaa.ts@audit.gov.mn

Аудитор:              У.Оюунтүлхүүр

Утас: .....              Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

---

1	Аудитын гэрчилгээ .....	3
2	Аудитын тайлан .....	5
2.1.	Оршил.....	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	8
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	8
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	8
2.8.1	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар .....	9
2.8.2	Төсвийн төвлөрүүлэн захирагчын шатанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар.....	9
2.8.2.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал .....	,
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	9
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	9
2.11.	Шилэн дансны мэдээлэл .....	11
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	11
2.13.	Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл: .....	11
2.14	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	12
3	Менежментийн захидал .....	
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	14

---

## 1 Аудитын гэрчилгээ

11/25 1-6/345

  
**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,  
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,  
Утас: (705) 2-27-34

2019.03.25 № 1-С/346

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Даланжаргалан сумын төсвийн Төвлөрүүлэн захирагчийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Даланжаргалан сумын төсвийн Төвлөрүүлэн захирагчийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Даланжаргалан сумын төсвийн Төвлөрүүлэн захирагч нь 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### **Үүрэг, хариуцлага**

Даланжаргалан сумын төсвийн Төвлөрүүлэн захирагч нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

## **2 Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Даланжаргалан сумын Засаг дарга 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч С.Уранцэцэг-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2,3-д заасны дагуу Даланжаргалан сумын Засаг дарга 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Даланжаргалан сумын Засаг дарга 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.03.19-наас 2019.03.21-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.03.22-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын аудитор У.Оюунтүлхүүр хариуцаж хэрэгжүүлэв.

Даланжаргалан сумын Засаг дарга 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар-т 2019.03.04-ны өдрийн 01/127 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Даланжаргалан сумын Засаг дарга талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Даланжаргалан сумын Засаг дарга нь Сумынхаа иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай соёлтой хүргэх өндөр боловсролтой, мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан чадварлаг бүтэцтэй төрийн захиргааны шилдэг байгууллага байх гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Даланжаргалан сумын Засаг дарга үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сумын удирдлага

Даланжаргалан сумын Засаг дарга удирдлага төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль

- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний 8 байгууллага, нэгж 2018 оны санхүүгийн тайландаа аудит хийж баталгаажуулахаас 8 байгууллага аудитад хамрагдсан байна.

Төрийн аудитын байгууллагаас Даланжаргалан сумын Засаг дарга эрх асуудлын хүрээний байгууллагад санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

<b>Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр</b>						
<b>№</b>	<b>Байгууллагын ангилал</b>	<b>Санал дүгнэлт гаргасан</b>	<b>Түүвэрлэсэн</b>	<b>Итгэл үзүүлсэн</b>	<b>Гэрээгээр хийлгэсэн</b>	<b>Аудитад хамрагдаагүй</b>
1	Төсвийн шууд захирагч	4	2		4	
2	ТТЗ	1	2			
	<b>Дүн</b>	<b>5</b>	<b>4</b>		<b>4</b>	

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Даланжаргалан сумын Засаг дарга мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Даланжаргалан сумын Засаг дарга санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг үнэлэхэд буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Даланжаргалан сумын Засаг дарга санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн програм хангамж ашигладаггүй байна.

Даланжаргалан сумын Засаг дарга дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт (Үр нөлөөтэй гэж үзлээ.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Даланжаргалан сумын Засаг дарга бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 4 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 1 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр цэвэр хөрөнгийн 1 хувиар сонгов.

*Цэвэр хөрөнгийг* материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь төлөвлөлтийн шатны суурийг хэвээр авсантай холбоотой юм.

Даланжаргалан сумын Засаг дарга 2018 оны цэвэр хөрөнгө 5,817,553.7 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 58,175.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь дундаж хувиар тооцсонтой холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## **2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн материаллаг биш боловч цаашид санхүүгийн тайлан, тодруулгад материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй зарим асуудлыг толилуулж байна.

Даланжаргалан сумын Засаг дарга болон төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагын 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагчийн хэмжээнд 59172.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч, 55481.5 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулав.

Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудлыг хэрхэн ангилж, шийдвэрлэсэн байдлыг энэ тайлангийн 2.13-т нэгтгэсэн байдлаар үзүүлэв.

Асуудлыг өмнөх түвшинд хийсэн аудитын явцад гарсан асуудал, төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад түүвэрт хамрагдсан асуудлаас илэрсэн асуудал гэсэн ангилалаар үзүүлэв. Үүнд:

2.8.1 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар

#### **Асуудал 1: Авлага**

2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар ХХОАТ-ын тооцооноос 2134212,5 төгрөг илүү шилжүүлж авлагын үлдэгдэлтэй гарсан байна

#### **Шийдэл:**

Авлагыг барагдуулж төсөвт төвлөрүүлэх акт тогтоох

2.8.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн шатанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 4 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд алдаа, зөрчил илрээгүй тул 4 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэн.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно. Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

### **2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй

### **2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн төвлөрүүлэн захирагч нь энэ

хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Даланжаргалан сумын Засаг дарга чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2018 онд 153 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 382555.0 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн орлогын татварын болон татварын бус орлого 307071.8 мянган төгрөг, санхүүгийн дэмжлэг 87413.2 мянган төгрөг нийт гүйцэтгэл 394485.0 мянган төгрөг буюу 103.1 хувь, зардлын нийт гүйцэтгэл 381,666.2 мянган төгрөг буюу 99.7 хувьтай байгаа нь шалтгаалжээ.

Татварын болон татварын бус орлогын төлөвлөгөөний биелэлтийг авч үзвэл:

№	Орлогын төрөл	2018 оны баталсан төсөв	2018 оны 12 сар тодотгол	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
1	Үйл ажиллагааны орлогын албан татвар	11350000	4000000	4105940.5	105940.5	102.65
2	Бусад татвар	25600000	96951900	104584201.9	7632302	107.87
3	Бууны татвар	1890000	1890000	1960000	70000	103.70
4	Улсын тэмдэгтийн хураамж	7472200	7472200	7139855	-332345	95.55
5	Хувь хүнээс суутгасан орлогын албан татвар			0	0	
6	Хог хаягдал үйлчилгээний хураамж	18000000	35292200	36895500	1603300	104.54
7	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	98250600	113428500	115835938.76	2407439	102.12
8	Төсөвт байгууллагуудын өөрийн орлого	1000000	1000000		-1000000	0.00
9	Хадгаламжийн хүүгийн орлого		28972000	29241362.34	269362.3	100.93
10	Хөрөнгө борлуулсны орлого		1552000	1572000	20000	101.29
11	Хүү торгуулийн орлого	250000	3200000	3200000	0	100.00
12	Ур рашаан ашигласны орлого		1382800	2537090	1154290	183.47
Нийт орлого		<b>163812800</b>	<b>295141600</b>	<b>307071888.5</b>	11930289	

Бусад татвар 7806,3 мянган төгрөгөөр давж биелсэн нь МАК компани цемент, тоног төхөөрөмж худалдан авалт их хийсэн хувь хүнээс суутгах татвар давсан байна.

Харин УТХ тасарсан шалтгаан нь Сумын тамгын газрын дарга нотариатын үйлчилгээг үзүүлдэг бөгөөд 11,12 сард тамгын газрын дарга өвчтэй байсан тул энэ орлого тасарсан байна.

Татварын болон татварын бус орлогын гүйцэтгэл 307071.8 мянган төгрөг, аймгаас орсон санхүүгийн дэмжлэг 87413.2 мянган төгрөг нийт 394485.0 мянган төгрөгийн орлого орсноос ИТХ болон ЗДТГ-ын санхүүжилтэд 381666.2 мянган төгрөг хуваарилж 12818,87 мянган төгрөгийг аймгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

## 2.11. Шилэн дансны мэдээлэл

Даланжаргалан сумын Засаг дарга Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

## 2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

## 2.13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Даланжаргалан сумын Засаг дарга 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт илэрсэн алдаа, зөрчлийн 93.7 хувь буюу 55481.5 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 3.6 хувь буюу 2134.2 мянган төгрөгийн зөрчилд хохирлыг барагдуулах төлбөрийн акт тогтоож, 2.5 хувь буюу 1452.8 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 0.2 хувь буюу 103.8 мянган төгрөгийн зөрчлийг засах, давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлээ.

Төрийн аудитын байгууллагаас аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил түүний шийдвэрлэлийн байдлыг дор нэгтгэн үзүүлэв. Үүнд:

(Мянган төгрөг)

№	Байгууллагын ангилал	Илрүүлэлт						Залруулга	
		Зөрчил		Алдаа		Бүгд дүн		Тоо	Дүн
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	ТТЗ								
2	ТШЗ	9	3690.8	2	55481.5	11	59172.3	2	55481.5
3	ТБӨААН								
	Дүн	9	3690.8	2	55481.5	11	59172.3	2	55481.5

## Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт

(Мянган төгрөг)

Үүнээс: Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт

№	Байгууллагын ангилал	Залруулаагүй алдаа, зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах санал		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
		1	ТТЗ										
2	ТШЗ	9	3690.8	1	2134.2	1	1452.8	7	103.8				
3	ТБӨААН												
	Дүн	9	3690.8	1	2134.2	1	1452.8	7	103.8				

### 2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Даланжаргалан сумын Засаг дарга 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Даланжаргалан сумын Засаг дарга 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудын хүрээний байгууллагад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн санал дүгнэлтийг нэгтгэн үзүүлэв.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудын хүрээний байгууллагад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн санал дүгнэлтийг нэгтгэн үзүүлэв.

**Санал дүгнэлтийн хэлбэр (Тоогоор)**

№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлтийн хэлбэр (Тоогоор)			Дүн
		Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	
1	ТШЗ	4			4
2	ТТЗ	1			1
	Дүн	5			5

### 3 Аудит хийсэн санхүүгийн тайлан

#### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>625,433,974.71</b>	<b>497,321,257.67</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>161,549,922.70</b>	<b>217,583,364.40</b>
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>161,549,922.70</b>	<b>217,583,364.40</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>161,549,922.70</b>	<b>217,583,364.40</b>
31211	Төрийн сангийн харилцах	161,549,922.70	217,583,364.40
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>185,613,261.00</b>	<b>72,950,709.50</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	3,012,120.00	0.00
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>47,640,157.00</b>	<b>2,289,168.50</b>
33510	Байгууллагаас авах авлага	46,605,811.50	2,289,168.50
33520	Хувь хүмүүсээс авах авлага	1,034,345.50	0.00
<b>33600</b>	<b>Зээлийн авлага</b>	<b>134,960,984.00</b>	<b>70,661,541.00</b>
<b>33610</b>	<b>Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага</b>	<b>134,960,984.00</b>	<b>70,661,541.00</b>
33612	Хувь хүмүүст олгосон зээл	134,960,984.00	70,661,541.00
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>115,000,000.00</b>	<b>0.00</b>
34600	Урьдчилж гарсан зардал	115,000,000.00	0.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>163,270,791.01</b>	<b>206,787,183.77</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>19,318,836.78</b>	<b>21,931,695.94</b>
35110	Тусгай зориулалттай материал	18,973,459.48	19,221,991.48
35130	Эм боох материал	345,377.30	2,709,704.46
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>143,194,354.23</b>	<b>183,480,927.83</b>
35410	Бичиг хэргийн материал	4,721,960.00	3,842,400.00
35420	Аж ахуйн материал	96,107,125.00	132,459,949.10
35430	Сэлбэг хэрэгсэл	7,217,727.33	2,552,127.33
35440	Түлш, шатах тослох материал	5,508,360.00	5,104,690.00
35450	Барилгын засварын материал	0.00	7,276,900.00
35460	Хүнсний материал	6,285,380.50	5,616,920.00
35470	Бусад хангамжийн материал	23,353,801.40	26,627,941.40
35600	Мал амьтад	757,600.00	1,374,560.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>4,341,857,171.78</b>	<b>5,320,232,438.26</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>4,341,857,171.78</b>	<b>5,320,232,438.26</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>4,338,095,000.44</b>	<b>5,187,329,719.72</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,391,885,238.77	3,846,156,320.86
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,136,484,647.15	-955,200.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	168,812,434.00	239,346,934.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-130,733,959.81	-137,371,440.24
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	401,700,596.68	482,084,134.81

39206	Хуримтлагдсан элэгдэл	-247,956,323.65	-281,053,809.34
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	344,398,568.05	390,410,531.32
39208	Хуримтлагдсан элэгдэл	-170,004,766.21	-197,737,194.64
39209	Зам, гүүрийн байгууламж	367,082,314.00	529,767,980.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-76,408,383.91	-113,116,615.27
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	13,702,000.00	13,702,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	472,177,358.30	490,321,608.30
39215	Хуримтлагдсан элэгдэл	-93,997,117.82	-108,061,362.53
39217	Ном	33,921,689.19	33,835,832.45
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>3,762,171.34</b>	<b>132,902,718.54</b>
39301	Програм хангамж	10,862,264.00	11,612,264.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-7,100,092.66	-8,875,545.46
39303	Бусад биет бус хөрөнгө	0.00	130,166,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>4,967,291,146.49</b>	<b>5,817,553,695.93</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>10,886,669.00</b>	<b>0.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>10,886,669.00</b>	<b>0.00</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>10,886,669.00</b>	<b>0.00</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	5,704,377.00	0.00
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>5,182,292.00</b>	<b>0.00</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	5,069,539.00	0.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	112,753.00	0.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>4,956,404,477.49</b>	<b>5,817,553,695.93</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>4,956,404,477.49</b>	<b>5,817,553,695.93</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,007,644,563.19	1,600,070,746.65
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	0.00	1,170,529,816.54
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>2,450,497,070.28</b>	<b>2,265,088,942.85</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	2,313,290,929.13	2,449,010,692.28
51220	Тайлант үеийн үр дүн	137,206,141.15	-183,921,749.43
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	498,262,844.02	781,864,189.89
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>4,967,291,146.49</b>	<b>5,817,553,695.93</b>

#### 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,723,899,650.39</b>	<b>3,187,416,390.53</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>154,676,199.03</b>	<b>303,871,888.48</b>
<b>110</b>	<b>Орлогын албан татвар</b>	<b>29,511,130.01</b>	<b>139,503,504.72</b>
<b>1100</b>	<b>Хувь хүний орлогын албан татвар</b>	<b>29,511,130.01</b>	<b>139,503,504.72</b>
110002	Үйл ажиллагааны орлого	12,927,842.90	4,105,940.50
110004	Хөрөнгө борлуулсны орлого	280,000.00	1,572,000.00
110008	Шууд бус орлого	16,303,287.11	133,825,564.22
<b>113</b>	<b>Хөрөнгийн албан татвар</b>	<b>2,609,000.00</b>	<b>1,960,000.00</b>
113002	Бууны албан татвар	2,609,000.00	1,960,000.00
<b>118</b>	<b>Бусад татвар, төлбөр, хураамж</b>	<b>122,556,069.02</b>	<b>162,408,383.76</b>
<b>1180</b>	<b>Бусад нийтлэг төлбөр, хураамж</b>	<b>122,556,069.02</b>	<b>159,871,293.76</b>
118001	Улсын тэмдэгийн хураамж	7,023,766.00	7,139,855.00
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	95,317,303.02	115,835,938.76
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	20,215,000.00	36,895,500.00
<b>1182</b>	<b>Байгалийн нөөц ашигласны төлбөр</b>	<b>0.00</b>	<b>2,537,090.00</b>
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	0.00	2,537,090.00
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>176,402,612.36</b>	<b>1,199,812,184.95</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>176,402,612.36</b>	<b>1,199,812,184.95</b>
120003	Торгуулийн орлого	11,620,952.00	3,200,000.00
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>164,781,660.36</b>	<b>1,196,612,184.95</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	18,015,708.00	18,283,475.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	852,400.00	1,081,805.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	145,913,552.36	1,177,246,904.95
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,392,820,839.00</b>	<b>1,683,732,317.10</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,170,360,300.00</b>	<b>1,134,568,138.70</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,073,639,900.00	1,055,315,000.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	96,720,400.00	79,253,138.70
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>29,902,939.00</b>	<b>80,083,995.70</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,100,000.00	33,284,134.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	0.00	1,505,680.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	15,216,160.00

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	17,951,400.00	22,385,491.70
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,851,539.00	7,692,530.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>192,557,600.00</b>	<b>469,080,182.70</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	0.00	381,666,200.00
132003	Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/	0.00	782.70
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	192,557,600.00	87,413,200.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,577,050,280.47</b>	<b>2,257,838,578.56</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,577,050,280.47</b>	<b>2,257,838,578.56</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,449,954,987.22</b>	<b>1,803,631,989.59</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>857,371,875.00</b>	<b>924,101,231.40</b>
210101	Үндсэн цалин	726,218,227.00	783,306,967.40
210102	Нэмэгдэл	58,672,586.00	60,377,700.00
210104	Урамшуулал	37,674,146.00	49,355,243.00
210105	Гэрээт ажлын хөлс	34,806,916.00	31,061,321.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>99,033,408.00</b>	<b>110,466,208.21</b>
210201	Тэтгэврийн даатгал	63,873,699.00	74,394,791.21
210202	Тэтгэмжийн даатгал	8,903,752.00	9,870,983.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,040,321.00	6,995,260.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,746,953.00	1,745,910.00
210205	Эрүүл мэндийн даатгал	17,468,683.00	17,459,264.00
